

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2024/07/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Өлгий хот	Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn
2024 он	Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
	Ахлах аудитор: У.Ербол Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

БӨА-2024/07/НА-СТА-ТШЗ

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Төсвийн захирагч



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА
А.ГАЛИЯ ТАНАА

2024.02.23 № 290
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сангаас 252 иргэнд 1,063.0 сая төгрөгийн хөнгөлттэй зээл олгосон байна.

Аудитын гол асуудал

Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сангийн хугацаа хэтэрсэн нийт 655.2 сая төгрөгийн авлагын 95.7 хувь буюу 637.5 сая төгрөгийн авлагыг хуулийн байгууллагад шилжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ж.АЙГҮЛ



Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,106,023,906.00	2,676,367,792.00
33	АВЛАГА	2,106,023,906.00	2,676,367,792.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,944,000.00	400,000.00
335	Бусад авлага	2,104,079,906.00	2,675,967,792.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,104,079,906.00	2,675,967,792.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,106,023,906.00	2,676,367,792.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,106,023,906.00	2,676,367,792.00
51	Засгийн газрын хувь оролцоо	2,106,023,906.00	2,676,367,792.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,106,023,906.00	2,676,367,792.00
51210	Өмнөх үеийн үр дүн	1,477,860,356.00	2,106,023,906.00
51220	Тайлант үеийн үр дүн	628,163,550.00	570,343,886.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,106,023,906.00	2,676,367,792.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,811,197,600.00	2,009,012,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	28,714,000.00	41,980,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	28,714,000.00	41,980,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	28,714,000.00	41,980,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	28,714,000.00	41,980,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,782,483,600.00	1,967,032,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	1,967,032,500.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	-	1,967,032,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,778,483,600.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,778,483,600.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	4,000,000.00	-
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	4,000,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,183,034,050.00	1,438,668,614.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,183,034,050.00	1,438,668,614.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,500,000.00	100,214,923.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,500,000.00	100,214,923.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,500,000.00	100,214,923.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,178,534,050.00	1,338,453,691.00

**Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2132	Бусад урсгал шилжүүлэг	615,037,935.00	579,852,476.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	615,037,935.00	579,852,476.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	28,714,000.00	43,924,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,714,000.00	43,924,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	534,782,115.00	714,677,215.00
213502	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	4,000,000.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	530,782,115.00	714,677,215.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	628,163,550.00	570,343,886.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	628,163,550.00	570,343,886.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,815,019,600.00	2,010,956,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	32,536,000.00	43,924,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	32,536,000.00	43,924,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	32,536,000.00	43,924,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	28,714,000.00	41,980,000.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	3,822,000.00	1,944,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,782,483,600.00	1,967,032,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,778,483,600.00	1,967,032,500.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	1,778,483,600.00	1,967,032,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	4,000,000.00	-
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	4,000,000.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,166,978,050.00	2,502,068,614.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,166,978,050.00	2,502,068,614.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,500,000.00	100,214,923.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,500,000.00	100,214,923.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,500,000.00	100,214,923.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,162,478,050.00	2,401,853,691.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,597,037,935.00	1,642,852,476.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,597,037,935.00	1,642,852,476.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,944,000.00	400,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,944,000.00	400,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	28,714,000.00	43,924,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,714,000.00	43,924,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	534,782,115.00	714,677,215.00

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213502	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	4,000,000.00	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	530,782,115.00	714,677,215.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(351,958,450.00)	(491,112,114.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
14	Бусад эх үүсвэр	351,958,450.00	491,112,114.00
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	351,958,450.00	491,112,114.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	351,958,450.00	491,112,114.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			1,477,860,356.00		1,477,860,356.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	1,477,860,356.00	0.00	1,477,860,356.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн			628,163,550.00		628,163,550.00
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,106,023,906.00	0.00	2,106,023,906.00
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,106,023,906.00	0.00	2,106,023,906.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	2,106,023,906.00	0.00	2,106,023,906.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			570,343,886.00		570,343,886.00
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,676,367,792.00	0.00	2,676,367,792.00

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,967,032,500.00	1,743,067,399.00	223,965,101.00	88.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,967,032,500.00	1,743,067,399.00	223,965,101.00	88.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	101,000,000.00	100,214,923.00	785,077.00	99.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	101,000,000.00	100,214,923.00	785,077.00	99.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчлэл	101,000,000.00	100,214,923.00	785,077.00	99.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,866,032,500.00	1,642,852,476.00	223,180,024.00	88.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,866,032,500.00	1,642,852,476.00	223,180,024.00	88.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,866,032,500.00	1,642,852,476.00	223,180,024.00	88.0
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,967,032,500.00	1,743,067,399.00	223,965,101.00	88.6
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,967,032,500.00	1,743,067,399.00	223,965,101.00	88.6
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	1,967,032,500.00	1,743,067,399.00	223,965,101.00	88.6

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт төсвөөс гүйлгээ гараагүй байна.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зорилго нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн үйл ажиллагааны чанарыг сайжруулах, үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг зорилтот, бүлэг, хүн амд оновчтой хүргэх замаар иргэдийг ажилтай, орлоготой болгох, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, монгол хүний амьдралын чанарыг сайжруулахад оршино.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

- Салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, дүрэм, журмын хэрэгжилтийг зохион байгуулах ажлын уялдаа холбоог хангах, төрийн захиргааны удирдлагын манлайлал, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах замаар үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг тасралтгүй дээшлүүлэх, дотоод, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх,
- Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлж, хамрах хүрээг өргөжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлж тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөдөлмөрлөх

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

таатай нөхцөл боломжийг бүрдүүлэх замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, хүн амын амьжиргааны түвшнийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх,

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн төсөвлөлт, зарцуулалт, тайланг ил тод, нээлттэй болгож, хяналтыг сайжруулах.

Үйл ажиллагааны чиглэл: Ажлын байрыг дэмжих, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байрыг дэмжих, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орон нутгийн хөгжил сан зэрэг 7 төсөл, арга хэмжээний хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын багц хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон олон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон олон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэв.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккрузал суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

ХХҮЕГ-ын даргын 2019 оны А/289 тоот тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг шинэчлэн батлах тухай журмыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 570.3 сая төгрөгөөр буюу 27 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	2,106,023.9	2,676,367.8	570,343.8
Бараа материал			
Үндсэн хөрөнгө			
Нийт хөрөнгө	2,106,023.9	2,676,367.8	570,343.8
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,106,023.9	2,676,367.8	570,343.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,106,023.9	2,676,367.8	570,343.8

Дансны авлага тайлант онд 570.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнээс санхүүгийн дэмжлэгийн авлага 2,675.9 сая төгрөг, татаас, санхүүжилтийн авлага 0.4 сая төгрөг байна.

Санхүүгийн дэмжлэгийн авлагыг дэлгэрэнгүй харуулбал:

Хүснэгт 1. Баян-Өлгий аймгийн ХЭДС-ийн авлагын судалгаа

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

№	Хөтөлбөрийн нэр	Авлагын эхний үлдэгдэл		олгосон санхүүгийн дэмжлэг		Төлсөн авлагын дүн			Авлагын эцсийн үлдэгдэл		Үүнээс: Хугацаа хэтэрсэн	
		хүн тоо	мөнгөн дүн	хүн тоо	мөнгөн дүн	хүн тоо		мөнгөн дүн	хүн тоо	мөнгөн дүн	хүн тоо	мөнгөн дүн
						төлсөн	Үүнээс дүүссэн					
1	Ажлын байрыг дэмжих	415	987,229.8	122	600,000.0	193	49	174,220.0	488	1,413,009.8	154	298,597.3
2	Залуучуудын ХЭДэмжих	32	153,129.3	-	-	10	10	60,288.8	22	92,840.5	22	92,840.5
3	Малчдын ХЭДэмжих	157	459,577.6	50	250,000.0	77	19	120,617.5	188	588,960.2	65	83,490.2
4	ХБИргээдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөр	134	180,738.8	44	88,000.0	83	27	45,220.2	151	223,518.6	25	43,332.1
5	Ахмадын ХЭДэмжих	91	152,811.0	36	125,000.0	69	24	54,275.6	103	223,535.4	24	23,159.4
6	Орон нутгийн хөгжил сан	8	160,593.6	-	-	7	1	36,490.0	7	124,103.3	7	124,103.3
7	Эмзэгтэйчүүдийн ХЭДэмжих	1	10,000.0	-	-	-	-	-	1	10,000.0	-	-
	нийт дүн	838	2,104,080.1	252	1,063,000.0	439	130	491,112.1	960	2,675,967.8	297	665,522.8

Эх сурвалж: ХЭДС-ийн 2023 оны санхүүгийн тайлан, мэдээ /

Хөтөлбөртэй холбоотой авлагын үлдэгдэл 2,104.0 сая төгрөг ба тайлант онд шинээр 1,063.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, 491.1 сая төгрөгийн авлага төлөгдөж 2,675.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Үүний 665.5 сая төгрөгийн авлага нь 2015-2020 онд олгосон 297 хүнтэй холбоотой хугацаа хэтэрсэн авлага байна. Нийт авлагын 75.1 хувь нь төлөгдөх хугацаа болоогүй хэвийн, 24.9 хувь хугацаа хэтэрсэн авлага байна.

Хугацаа хэтэрсэн санхүүгийн дэмжлэгийн авлагыг насжилтаар нь авч үзвэл:

Хүснэгт 2. Авлагын насжилт / мянган төгрөгөөр/

огноо	зээл авсан хүний тоо	Хугацаа хэтэрсэн зээл
2015	31	14,242.9
2016	7	4,616.8
2017	29	26,573.5
2018	60	184,845.9
2019	110	286,266.7
2020	55	142,186.8
2021	5	6,790.0
нийт	297	665,522.7

Эх сурвалж: ХЭДС-ийн 2023 оны санхүүгийн тайлан, мэдээ

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хугацаа хэтэрсэн нийт зээлийн авлага 665.5 сая төгрөгийн 92.1 хувийг буюу 613.3 сая төгрөгийг 2018-2020 онд олгосон зээл эзэлж байна.

Хүснэгт 1. Хугацаа хэтэрсэн авлагын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

№	Хөтөлбөр	Ажлын хэсгийн шийдвэр	Үлдэгдэл	Хуулийн байгууллага	Сураггүй болсон	Нас барсан
1	Ажлын байрыг дэмжих	428,600.00	298,597.30	281,991.30	2,330.00	13,376.00
2	ХБИргээдийн ажлын байрыг дэмжих	62,500.00	43,331.50	37,005.00	-	6,326.50
3	Залуучуудын ХЭДэмжих	153,000.00	92,840.50	92,840.50	-	-
4	Ахмадын ХЭДэмжих	42,500.00	23,159.30	20,559.40	-	2,600.00
5	Малчдын ХЭДэмжих	261,000.00	83,490.20	80,990.20	900.00	2,500.00
6	Орон нутгийн хөгжил сан	164,000.00	124,103.30	124,103.30		
	Нийт	1,111,600.00	665,522.10	637,489.70	3,230.00	24,802.50

Эх сурвалж: ХЭДС-ийн 2023 оны санхүүгийн тайлан, мэдээ

Хугацаа хэтэрсэн нийт авлага 655.2 сая төгрөг ба үүнээс 95.7 хувь буюу 637.5 сая төгрөгийн авлагыг хуулийн байгууллагад шилжүүлсэн, 3.2 сая төгрөгийн авлагын эзэн нь тодорхой бус, 24.8 сая төгрөгийн хариуцагч эзэд нь нас барсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн төслийг 2,431.2 сая төгрөгөөр боловсруулан ХХҮЕГ-т хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийн төслийг хянаж, 1,967.0 сая төгрөгөөр баталж төсвийн төслийн саналаас 463.5 сая төгрөгөөр бууруулсан байна.

Гүйцэтгэлээр ХХҮЕГ-аас 1,743.8 сая төгрөгийн санхүүжилт авч 1,743.8 сая төгрөгийг зарцуулан жилийн эцэст 223.9 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,743.0 сая төгрөг буюу 88.6 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
72102	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	1,967,032.5	1,743,067.3	223,964.3	88.6%
80224	Зөвлөл, хороо, комиссын гишүүд	6,000.0	5,840.0	160.0	97.3%
82602	ХБИ-ийн ажлын байрыг дэмжих	205,097.0	173,546.0	31,551.0	84.6%
82616	ЗГ, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	0	0	0	0
82619	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ	69,693.5	62,520.0	7,173.4	89.7%
82620	Хөдөлмөрт бэлтгэх сургалт	76,850.0	50,876.0	25,974.0	66.2%

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

82621	Аж ахуй эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг	1,125,712.0	1,036,227.3	89,484.7	92%
82622	Түр ажлын байрыг дэмжих	388,680.0	319,683.1	68,996.9	82.2%
82623	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зардал	95,000.0	94,374.9	625.0	99.3%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвөөр гүйлгээ хийгдээгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 57.3 сая төгрөгийн бараа материал худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/126 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 1,438.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 21.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор батлагдсан төсөвт багтаан үйл ажиллагаагаа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж ажилласан ба алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 677,352.0 мянган төгрөгийн 13 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 1,142,415.0 мянган төгрөгийн 93 гүйлгээг байршуулахаас цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 38,250.4 мянган төгрөгийн 4 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 105,718.0 мянган төгрөгийн 13 мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, ер авлага үүсгэсэн шийдвэрийг мэдээлээгүй, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын 8 мэдээлэл, санхүүгийн хагас жилийн тайлан, байгууллагын батлагдсан төсөв, дараа жилийн төсвийн төсөл, бусад мэдээллүүдийг хугацаа хоцорч мэдээлсэн, шилэн дансны мэдээллийн хэрэгжилт 67.5 хувьтай байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчил илрээгүй.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Нийт дүн					

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан аудитаар эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн тул сангийн төсвийн зарцуулалтыг гүйцэтгэлийн шалгалтаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Аудитаар нийт 170,000.9 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 170,000.9 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

5.1 Төлбөрийн акт

Байхгүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар 170,000.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгөв.

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь 2023 оны жилийн эцсийн байдлаар 297 иргэнтэй холбоотой нийтдээ 655,522.2 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн хөнгөлөлттэй зээлийн авлагын үлдэгдэлтэй байна. Үүнээс 282 иргэнтэй холбоотой 637,489.7 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн хөнгөлөлттэй зээлийн авлагыг барагдуулахаар хууль хяналтын байгууллагад 2018-2023 онд шилжүүлсэн байна. Мөн нас барсан 11 иргэний 24,802.5 мянган төгрөгийн, хариуцагч нь сураггүй болсон 4 иргэний 3,230.0 мянган төгрөгийн зээлийн авлага байна. Дээрх хугацаа хэтэрсэн хөнгөлөлттэй зээлийн авлагын үлдэгдэл баталгаатай эсэх нь тодорхой бус, үлдэгдэл нь баталгаажаагүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.2 -т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Нягтлан бодлох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 677,352.0 мянган төгрөгийн 13 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 1,142,415.0 мянган төгрөгийн 93 гүйлгээг байршуулахаас цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 38,250.4 мянган төгрөгийн 4 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 105,718.0 мянган төгрөгийн 13 мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн шийдвэрийг мэдээлээгүй, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын 8 мэдээлэл, санхүүгийн хагас жилийн тайлан, байгууллагын батлагдсан төсөв, дараа жилийн төсвийн төсөл, бусад мэдээллүүдийг хугацаа хоцорч мэдээлсэн, шилэн дансны мэдээллийн хэрэгжилт 67.5 хувьтай байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 4.1.4-т “хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх”, 5 дугаар зүйлийн 5.1.4-т “мэдээллийг тогтмол шинэчилж байх”, 6 дугаар зүйлийн 6 дугаар зүйлийн 6.1-д “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6 дугаар зүйлийн 6.4.5- т” цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 7 дугаар зүйлийн 7.1-д “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ”, Засгийн газрын 2019 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Байхгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа	Мэдээллийг тусгахгүй	Буруу тусган илэрхийлсэн	Үүнээс		Зөвлөмж
				Залруулсан	Залруул аагүй	

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

			орхигдуулсан									
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хугацаа хэтэрсэн авлага	1	28,032.5			1	28,032.5						
Дүн	1	28,032.5			1	28,032.5						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны хуулийн хэрэгжилт 67.5 хувьтай байна	1	143,968.4			1	143,968.4		
Дүн	1	143,968.4			1	143,968.4		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								